



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2023 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, А.Адъяасүрэн, П.Анужин, Б.Баярсайхан, Х.Булгантуяа, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Д.Өнөрболор, Д.Сарангэрэл, Б.Саранчимэг, Ч.Ундрам нарын гишүүдээс 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Идэрбат

-Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн гишүүн:

П.Анужин

-Улсын Их Хурлын гишүүн

Б.Баярсайхан

-Улсын Их Хурлын гишүүн

Б.Бейсен


-Улсын Их Хурлын гишүүн

Б.Жаргалмаа

-Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсэг (Ц.Идэрбат)-т зөвшөөрсүгэй.

НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



П.АНУЖИН